

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ЭХ ОРОНЧДЫН НЭГДСЭН ЭВСЛИЙН ТЭРГҮҮН Г.ГАНБАТ ТАНАА

Бид Эх орончдын нэгдсэн эвсэл (цаашид “Эвсэл” гэх) УИХ-ын 2016 сонгуулиар иргэд, хуулийн этгээдээс хүлээн авсан хандив, түүний зарцуулалтын тайланд аудит хийлээ.

Удирдлагын үүрэг хариуцлага

Энэхүү санхүүжилт, зарцуулалтын тайланг Монгол улсын холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн үнэн зөв бэлтгэж, толилуулах нь эвслийн үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад санхүүжилт, зарцуулалтын тайланг алдаа зөрчилгүй бэлтгэж, шударгаар толилуулахтай холбоотой дотоод хяналтын системийг зохиож, түүнийгээ хэрэгжүүлэн, түүнийгээ тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож, хэрэглэх, нөхцөл байдалд тохируулан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх зэрэг зүйлс багтана.

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан энэхүү санхүүжилт зарцуулалтын тайлангийн талаар аудитын дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэдэг. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудыг баримталж, санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүжилт зарцуулалтын тайлан дахь дүн болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан, юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн тооцооллыг хийхтэйгээр холбоотойгоор, аудитор эвслийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг сонгож хэрэглэх зорилгоор санхүүгийн үйл ажиллагааны тайланг бэлтгэж, шударгаар толилуулахад зориулан хэрэглэж байгаа дотоод хяналтыг авч үздэг. Мөн

санхүүгийн тайлагналыг бүхэлд нь үнэлэхээс гадна, эвслийн зүгээс хийсэн томоохон тооцооллуудын үндэслэлтэй байдал, хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан.

Бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэдэгт бид итгэж байна.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАНГИЙН ҮРГЭЛЖЛЭЛ

Дүгнэлтийн тайлбар

Эх орончдын нэгдсэн эвсэл нь 2016 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдээс нийт 9,000,000 төгрөгийн дундын сан байгуулсан ба үүнээс 8,982,100 төгрөг зарцуулсан гэж бидэнд мэдээлсэн.

Эх орончдын нэгдсэн эвсэл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Монгол улсын хуулийн дагуу Нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан бэлтгээгүй байсан. Эвсэл нь энэхүү нэр дэвшигчдээс бүрдүүлсэн дундын сан ба түүний зарцуулалтыг энгийн бүртгэлийн системийг ашиглан эмхэтгэж, Санхүүжилт зарцуулалтын тайлан бэлтгэсэн байна.

Аудитын дүгнэлт

Бидний дүгнэлтээр, дүгнэлтийн тайлбар хэсэгт дурьдсан зүйлсийг харгалзан үзсэн тохиолдолд энд хавсаргасан санхүүжилт зарцуулалтын тайлан нь УИХ-ын сонгуулийн үеэр хүлээн авсан мөнгөн хөрөнгийн зарцуулалтын санхүүгийн гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн байна. Түүнчлэн энэхүү санхүүжилт зарцуулалтын тайланд тусгагдсан санхүүжилт болон зарцуулалтууд нь хангалттай бөгөөд хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байна.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.АНДРУШ

**ЭХ ОРОНЧДЫН НЭГДСЭН ЭВСЛИЙН УИХ-ЫН 2016 ОНЫ
СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН**

2016 оны 7 дугаар сарын 22-ны өдөр

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн		Бүгд
		Мөнгөн дүн	Мөнгөн бус	
1	Хуулийн этгээдээс өгсөн хандив			
2	Иргэдээс өгсөн хандив			
3	Намын өөрийн хөрөнгө			
4	Нэр дэвшигчдийн дундын сан	9,000,000		9,000,000
	Орлогын дүн	9,000,000		9,000,000
1	Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал			
2	Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах зардал			
3	Эвсэл, нэр дэвшигчийг сурталчлах зардал	7,900,000		7,900,000
4	Шуудан холбооны зардал	131,000		131,000
5	Унааны зардал	400,000		400,000
6	Албан томилолтын зардал			
7	Бичиг хэргийн зардал	551,100		551,100
8	Хөлс, урамшуулалын зардал			
	Зардлын дүн	8,982,100		8,982,100
	Үлдэгдэл	17,900		17,900

Жич: Хувь хүн, хуулийн этгээдээс өгсөн хандив байхгүй болно.